



# ИНДОНЕЗ -ООС МЭНДЧИЛЖ байна!

Дэлхий даяарх Тэнгэрлэг Эцэгийн  
хүүхдүүдийн талаар олж мэд.



Индонез нь Зүүн Өмнөд  
Азид оршдог улс юм. Энэ улс  
17,000 гаруй аралтай! Энэ улсад  
280 сая орчим хүн амьдардаг.



## ӨСӨЖ БУЙ СҮМ

Ерөнхийлөгч Рассэлл М.Нэлсон 2019 онд  
нийслэл Жакарта дахь гишүүдэд зочилж байжээ.  
Мөн 2023 оны 4-р сарын Ерөнхий чуулган дээр  
тэрээр тэнд ариун сүм баригдана гэж зарласан!

## ШҮТЛЭГ БИШРЭЛИЙН ГАЗАР



Зүүн Өмнөд Азийн хамгийн  
том Исламын сүм Индонезод  
байдаг. Мөн дэлхийн  
хамгийн том Буддын  
шашны хийд энд бий.

## ЧИ МАНАЙ ОРНЫ ХЭЛЭЭР ЯРЬДАГ УУ?

Selamat  
pagi!

Halo!

Rahajeng  
semeng!



Албан ёсны хэл нь индонез. Индонезод  
хүмүүс 700 гаруй хэлээр ярьдаг. "Олон  
боловч нэг" гэсэн тэдний үндэсний  
уриа нь эв нэгдлийг илэрхийлдэг.

## ЛУУНЫ ЭХ ОРОН

Комодо луу бол дэлхийн хамгийн  
том гүрвэл юм. Тэд уртаараа  
10 фут (3 метр) хүртэл өсдөг!



ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ КАНЭР ЖИЛЛЭТ

ҮЙЛ  
АЖИЛЛАГАА

## БАТИК БУДДАГ ЗУРАГ

Батик бол даавуун дээр өнгөөр  
буддаг урлагийн төрөл юм.  
Чи ч бас үүнийг хийж чадна!  
Цаасан дээр шингэн цавуу  
ашиглан уран дүрс хий.  
Хатангуут нь цавууны ирмэг  
хоорондхыг усан будгаар буд.



## НАСИ УДУК

1. **2 аяга цагаан будаа** угаа. Будаагаа нэг цагийн турш усанд дэвтээгээд дараа нь шүүнэ.
2. Тусдаа саванд **2 аяга наргил модны самрын тос** хий. Дээр нь **2 хумс саримс, 1 шанцайны иш, 1 цайны халбага давс** нэм. Холиод буцалгана.
3. Дээр нь будаагаа нэмнэ. Таглаад 15-20 минутын турш будаагаа болтол бага гал дээр чанана.
4. Галыг унтраагаад таглаатай нь 10 минут байлгана. Чанасан өндөг, шарсан сонгино эсвэл бусад амтлагчтай хамт зооглоно.

ЖОР

Томчуудаас  
тусламж  
аваарай!



## ШӨНИЙН НОЙР

Бид гүйх, тоглох, ажиллах эрч  
хүчтэй байхын тулд унтах  
хэрэгтэй. Орой бүр тогтмол цагт  
унтахыг хичээ. Унтахаасаа өмнө  
тайвшрахад чинь туслах ямар  
нэгэн зүйл хий.

ЭРҮҮЛ  
МЭНДИЙН  
ЗӨВЛӨГӨӨ